



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ

МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?





Энэхүү гарын авлагыг "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд боловсруулав.

Монголбанкны зөвшөөрөлгүйгээр товхимлыг цахим болон хэвлэмэл байдлаар, бүтнээр, эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

© Монголбанк

Үнэгүй тараагдана.



1.1. Мөнгө, мөнгөний үнэ цэнэ

Мөнгө нь өөрийн үнэ цэнээр бусад барааны үнэ цэнийг илэрхийлэх боломжийг олгодог санхүүгийн онцгой хэрэгсэл юм. Мөнгөний мөн чанар, үүсэл хөгжлийг ойлгохын тулд та дараахь асуултыг өөрөөсөө асуух хэрэгтэй: “Мөнгөгүй ертөнцөд та ямар нэг үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг хэрхэн худалдан авах вэ?”

”

Мөнгөний мөн чанар нь эд зүйлс биш, нийгмийн харилцаа болдог оршдог

“





ОДОО & ӨНГӨРСӨН

Бартерын жишээ: 1 гүү = 12 төлөг, 1 морь = 15 төлөг, 1 шар = 32 төлөг гэх мэт мөнгөний үүргийг эд бараа гүйцэтгэдэг байсан.

Бартерын худалдаа



Барааг бараагаар арилжаалах

-  Худалдааны хоёр талын солилцох барааны сонголтууд нийцэх ёстой;
-  Бараа бүтээгдэхүүн нь хуваагдах боломжгүй тохиолдолд хоёр талын арилжааг хүсэж байгаа хэмжээ нь таарахгүй;
-  Урт хугацаанд барааны үнэ цэнэ нь алдагдана;
-  Бүтээгдэхүүний үнэ цэнийг илэрхийлэхэд хэцүү.

Асуулт: Ирээдүйд цаасан мөнгийг хэрэглэсээр байх уу? Хөгжлийн дараагийн үе шат хаашаа чиглэж байна вэ?

МӨНГӨНИЙ ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ


Мөнгө бол бүтээгдэхүүн үйлчилгээний төлбөрт төлж болох санхүүгийн хэрэгсэл юм.

Мөнгөний шинж чанар

Х	Тоологдохуйц байх
Ө	Залгамж чанартай байх
Г	Хуваагдмал нэгжтэй байх
Ж	Урт хугацааны хэрэглээтэй байх
И	Нийт хэмжээ нь хязгаарлагдмал
Л	Бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байх



МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?



Зураг 1.1. Мөнгөний түүхэн хөгжил, цаашдын хандлага

Эд зүйлс дундаа зоос, металл нь мөнгөний үүргийг олон жил гүйцэтгэсэн ба бараа бүтээгдэхүүнтэй харьцуулахад удаан хадгалж болох, тээвэрлэж явахад хөнгөхөн зэрэг олон давуу талтай байв. Гэсэн ч бизнес эрхлэхэд хангалттай аюулгүй байж чадаагүй тул амлалтын бичиг ашиглаж эхэлсэн нь одоогийн цаасан мөнгөний эхлэл болсон юм. Технологийн эрин үед шилжсэнээр дансны болон цахим мөнгө ашиглаж эхэлсэн бөгөөд цаашид бий болох мөнгөний хувьсал нь хүмүүсийн өдөр тутмын амьдралын төлбөр тооцоог хөнгөвчилж, хурдасгаж байна.

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ хуулийн хоёрдугаар бүлгээс Монгол улсын мөнгөн тэмдэгтэй холбоотой хууль тогтоомжийг уншина уу.



1

Төлбөрийн хэрэгслийн үүрэг

Бүтээгдэхүүн, үйлчилгээг зээлээр худалдан авахад үүссэн өр төлбөрийг төлөх хэрэгсэл хэрэгтэй.



Өртгийн хэмжүүрийн үүрэг

Таваар гүйлгээнд гарахын өмнө түүний үнэ цэнэ хэмжигдсэн байх ёстой бөгөөд аливаа таваарын өртгийг мөнгөөр хэмждэг.

2

3

Хуримтлалын хэрэгслийн үүрэг

Энэ нь аливаа бараа таваарыг хүссэн цагтаа худалдан авах боломжийг хангасан бэлэн мөнгөний нөөц санг бий болгоно гэсэн үг юм.



Гүйлгээний хэрэгслийн үүрэг

Энэ үүргийн тусламжтайгаар бид өөрсдийн хэрэгцээт зүйлээ худалдан авах боломжтой болдог.

4

Зураг 1.2. Мөнгөний гүйцэтгэх үүрэг



МӨНГӨ ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ

Мөнгийг бусдаас зээлдэж ашигласныхаа төлөө тодорхой хэмжээний төлбөр төлдөг. Хугацаа дуусах үед анх зээлсэн мөнгөө хүүтэй нь буцааж өгөх ёстой. Харин мөнгийг бусдад зээлдүүлсэн тохиолдолд тодорхой хугацаанд мөнгөө ашиглуулсны төлөөх төлбөрийг хүү хэлбэрээр анх зээлсэн мөнгөнийхөө хамтаар авна.

МӨНГИЙГ ХУРИМТЛУУЛАХ

Мөнгийг хэрэгцээт зүйлдээ зарцуулахаас өмнө олсон орлогынхоо 10 хүртэл хувийг боломжоороо ирээдүйн хэрэгцээнд зориулан хуримтлуулах нь зөв байдаг. Хэрэв мөнгийг бэлэн мөнгө хэлбэрээр өөртөө хадгалсан тохиолдолд тэр нь инфляцын нөлөөнд автаж үнэ цэнээ алддаг. Харин банкинд хадгалах зэргээр эргэлтэд оруулбал өсөх боломжтой.

МӨНГИЙГ АРИЛЖААЛАХ

Мөнгө танд өөрийнхөө үнэ цэнэтэй зүйлийг бусдад зориулж, хариуд нь өөрт хэрэгтэй байгаа зүйлээ олж авах боломжийг олгодог. Хэрэв хэн нэгэн үйлчилгээ үзүүлээч гэж хүсвэл, та үзүүлсэн үйлчилгээнийхээ төлбөрт мөнгө авна. Дараа нь та хүсэж буй бараа, үйлчилгээндээ өөрийн олсон мөнгийг зориулах боломжтой болно.

Зураг 1.3. Мөнгөний хэрэглээ




1.2. Орлого, түүнийг бүрдүүлэх

Мөнгө нь өөрийн үнэ цэнээр бусад барааны үнэ цэнийг илэрхийлэх боломжийг олгодог санхүүгийн онцгой хэрэгсэл юм. Мөнгөний мөн чанар, үүсэл хөгжлийг ойлгохын тулд та дараах асуултыг өөрөөсөө асуух хэрэгтэй: “Мөнгөгүй ертөнцөд та ямар нэг үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг хэрхэн худалдан авах вэ?”

Орлого нь биеийн болон оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болдог. Хувь хүн өөрт байгаа мөнгөө хадгалуулах эсвэл хөрөнгө оруулах шийдвэр гаргасны үр дүнд орлого олох боломж бүрддэг.

” Мөнгөний мөн чанар нь эд зүйлс биш, нийгмийн харилцаа болдог оршдог

“



Зураг 1.4. Орлогын эх үүсвэр



МӨНГӨӨ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ?

Хувь хүн аливаа хэлбэрийн аж ахуй эрхэлж орлого олбол энэ нь бизнесийн орлого болно. Бизнес эрхлэхийн тулд үндсэн дөрвөн төрлийн нөөц ашиглах ба үүнд газар, капитал, хөдөлмөр, ур чадвар зэрэг орно.



Зураг 1.5. Бизнесийн орлого бий болгоход шаардагдах нөөц



Хүмүүсийн хооронд нас чацуу, мэргэжил ижил гээд нийтлэг шинж олон ч, амьдралын түвшин өөр өөр байх үзэгдэл элбэг. Үүний нэг шалтгаан нь тухайн хүмүүсийн орлогын ялгаа юм. Тухайлбал, зарим хүн хэд хэдэн эх үүсвэрээс орлого олж байхад зарим нь орлогын ганц эх үүсвэртэй, зарим хүн өөрийн гэсэн орлогын эх үүсвэргүй байдаг.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

1



Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх замаар ажил албан тушаалаа өөрчлөх

2



Давхар ажил хийх

3



Өрхийн гишүүдийн хэн нэгнийг ашигтай бизнес эрхлүүлэх

4



Илүүдэл эд зүйлийг худалдан борлуулах

5



Банк болон бусад байгууллага иргэдээс зээл авах

Зураг 1.6. Орлого нэмэгдүүлэх арга зам



1.3. Зардал, түүнийг хэмнэх арга

Мөнгийг олохоос илүү зөв зарцуулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Учир нь хэрэгцээ цаг ямагт байдаг бөгөөд өсөн нэмэгдэх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, хүний хэрэгцээ нь хязгааргүй, хэрэгцээг хангах мөнгө хязгаартай. Иймд хязгаарлагдмал нөөц буюу мөнгийг хязгааргүй хэрэгцээнд зөв зохистой зарцуулах нь хувь хүнээс илүү их ур чадвар шаардана.



Маш олон хүн олоогүй мөнгөө үрж, хүсээгүй зүйлээ авч, дургүй хүнээ дагуулах гэдэг.



Хувь хүн эсвэл өрх гэр зардлаа төлөвлөхдөө дараах зүйлст анхаарвал зохино.

- Зарцуулалт хийх зүйлс нь хэрэгцээ юу? эсвэл хүсэл үү? гэдгийг ялгаж таних;
- Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтийг харгалзаж үзэх;
- Бэлэн мөнгөөр худалдан авалт хийх үед мөнгөний хариултыг бага гэлтгүй авч байх;
- Амьдралын энгийн зүйлсээс таашаал авах;
- Эд зүйлсээ гамнаж тордох зэрэг орно.

	Худалдан авах чадвартаа тохирсон хэрэглээг сонгох		Зарим үйлчилгээнээс татгалзаж өөрөө гүйцэтгэх
	Эрүүл мэнддээ анхаарч эм тарианд зардал гаргахгүй байх		Архи, тамхи хэрэглэдэг муу зуршлыг болих
	Баяр ёслолыг өндөр зардлаар тэмдэглэхээс татгалзах, гэр бүлтэйгээ жаргалтай байх		




Зураг 1.7. Хэрэглээг танах арга








Дэлхийн улс орнуудад орлогоо хуваарилдаг хамгийн энгийн бөгөөд их ашиглагддаг арга нь 50/20/30-ийн төсөвлөх дүрэм байдаг. Энэхүү дүрмийн давуу тал нь та өөрийн орлогын тодорхой түвшнээс тухайн төрлийн зардлыг давуулахгүй гэж зорилго тавьснаар тогтвортой хуримтлал хийх боломж олгоно.

ОРЛОГОД ЭЗЛЭХ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХУВЬ




30% ХҮСЭЛ

-  Хобби
-  Өөрийн гадаад үзэмж
-  Кино, урлаг

50% ХЭРЭГЦЭЭ

-  Байрны төлбөр
-  Хоол, хүнс
-  Эрүүл мэнд
-  Даатгал
-  Өдөр тутмын хэрэглээ

20% ХАДГАЛАМЖ


-  Хуримтлал
-  Хөрөнгө оруулалт
-  Гэнэтийн зүйл



Зураг 1.8. Орлогод эзлэх зардлын зохистой хувь¹

Хүн хэрэглээгээ зөв зохистой, аль болох хүрээлэн буй байгаль орчинд хор хөнөөлгүй, нийгэм-эдийн засгийн хувьд үр ашигтай байх хэмжээнд хангах нь XXI зууны дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага болсон “Тогтвортой хөгжил”-ийн үзэл санаанд нийцэх юм. Ингэснээр тогтвортой амьдралын хэв маяг бий болно.

¹ Өрхийн орлого, зарлагын зохистой хэмжээний 50/20/30-ийн дүрэм- Энэхүү арга нь өөрийн орлогыг анх удаа төсөвлөх гэж оролдож байгаа гэр бүлийн хувьд ашиглавал тохиромжтой бөгөөд цаашдаа илүү нарийвчлалтай, өөртөө тааруулан орлогоо хуваарилах боломжтой.



Төсөвчин



on GooglePlay



on App Store

Энэхүү аапликейшн нь өөртөө хуримтлал тооцоологч, хадгалагч, зээл тооцоологч, ипотек, төсөвлөгч зэрэг тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuugiinbolovсрол.mn

- /mongolbank.mn
- /Санхүүгийн боловсрол
- /@mongolbank_mn
- www.mongolbank.mn
- /Mongolbankmn
- info@mongolbank.mn
- 11 310081

